

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ХҮНИЙ ЭРХИЙН ДЭД ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ГАЗАР

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ХҮНИЙ ЭРХИЙН ДЭД ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА

2025 оны 12 дугаар сарын 23-ны өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2 - 4
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	5 - 28

1.	Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль болон Гамшгаас хамгаалах тухай хуулийн хүний эрхийн хэрэгжилтийн талаарх үнэлгээтэй танилцах асуудал	6 - 21
2.	Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенцын хэрэгжилтийг сайжруулах, зарим шаардлагатай арга хэмжээ авч хэрэгжүүлэх тухай санал, зөвлөмжийг хэлэлцэнэ	21 – 25
3.	Хүний эрхийн дэд хорооны 2025 оны үйл ажиллагааны тайлан, 2026 оны төлөвлөгөөний төсөл	25 – 28

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
Хүний эрхийн дэд хорооны 12 дугаар сарын 23-ны өдөр
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Хүний эрхийн дэд хорооны дарга С.Эрдэнэболд ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 11 гишүүнээс 6 гишүүн хүрэлцэн ирж, 54.5 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 04 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Чөлөөтэй: О.Алтангэрэл, Ж.Баярмаа, М.Нарантуяа-Нара.

Нэг.Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль болон Гамшгаас хамгаалах тухай хуулийн хүний эрхийн хэрэгжилтийн талаарх үнэлгээтэй танилцах асуудал

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүний эрхийн Үндэсний Комиссын Хүний эрх хамгаалагчийн асуудал хариуцсан гишүүн С.Дондов, Хүний эрхийн Үндэсний Комиссын референт Р.Рэнцэндулам, Монголын Эмнести Интернэшнлийн Өсөлт, хөгжил хариуцсан зохицуулагч Г.Сүхбат, Хүний эрх хөгжил төвийн Гүйцэтгэх захирал У.Мандхайцэцэн, Хүний эрх хөгжил төвийн Тэргүүн Г.Уранцоож, Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Хүний эрхийн идэвхтэн, олон нийтийн зөвлөлийн гишүүн Б.Навчаа, Ц.Баттулга, А.Баярсайхан, мөн аймгийн Даланжаргалан сумын Хүний эрхийн идэвхтэн, олон нийтийн зөвлөлийн гишүүн Ө.Оюунцэцэг, Улаанбадрах сумын Хүний эрхийн идэвхтэн, олон нийтийн зөвлөлийн гишүүн Д.Гантөр, Дорнод аймгийн Баяндун сумын Хүний эрхийн идэвхтэн, олон нийтийн зөвлөлийн гишүүн Д.Хишигт, Хүний эрхийн Үндэсний Комиссын Өвөрхангай аймаг дахь шинжээч Г.Сүхбаатар нар байлцав.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Б.Баярсайхан нар байлцав.

“Монгол Улсын зарим хууль, арга хэмжээний төлөвлөгөөний тодорхой зүйл, заалтын хэрэгжилтийг үнэлэх, орон нутгийн иргэдийн үнэлгээний тухай товч танилцуулга болон Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.6 дахь заалтын хэрэгжилт” сэдвээр илтгэлийг Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Хатанбулаг сумын Хүний эрхийн идэвхтэн, олон нийтийн зөвлөлийн гишүүн Б.Навчаа, Дорнод аймгийн Баяндун сумын Хүний эрхийн идэвхтэн, олон нийтийн зөвлөлийн гишүүн Д.Хишигт нар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргалын тавьсан асуултад Хүний эрхийн Үндэсний Комиссын Хүний эрх хамгаалагчийн асуудал хариуцсан гишүүн С.Дондов, Дорнод аймгийн

Баяндун сумын Хүний эрхийн идэвхтэн, олон нийтийн зөвлөлийн гишүүн Д.Хишигт нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүд Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль болон Гамшгаас хамгаалах тухай хуулийн хүний эрхийн хэрэгжилтийн талаарх үнэлгээтэй танилцав.

Уг асуудлыг 15 цаг 39 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенцын хэрэгжилтийг сайжруулах, зарим шаардлагатай арга хэмжээ авч хэрэгжүүлэх тухай санал, зөвлөмжийг хэлэлцэнэ

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүний эрхийн Үндэсний Комиссын референт Б.Янжмаа, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөрийн “Оролцоо” төслийн техникийн зөвлөх Ц.Мандхайхатан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Б.Баярсайхан нар байлцав.

Улсын Их Хурлын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо болон Хүний эрхийн дэд хорооноос “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн тухай конвенцыг хэрэгжүүлэх оролцооны арга замуудыг бэхжүүлэх нь” сэдэвт бодлогын хэлэлцүүлгээс гарсан санал, зөвлөмжийг Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Улсын Их Хурлын гишүүд Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенцын хэрэгжилтийг сайжруулах, зарим шаардлагатай арга хэмжээ авч хэрэгжүүлэх тухай санал, зөвлөмжтэй танилцав.

Уг асуудлыг 15 цаг 48 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Хүний эрхийн дэд хорооны 2025 оны үйл ажиллагааны тайлан, 2026 оны төлөвлөгөөний төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Б.Баярсайхан нар байлцав.

Хүний эрхийн дэд хорооны дарга С.Эрдэнэболд Хүний эрхийн дэд хорооны 2025 оны үйл ажиллагааны тайлан, 2026 оны төлөвлөгөөний төслийг танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Улсын Их Хурлын гишүүд Хүний эрхийн дэд хорооны 2025 оны үйл ажиллагааны тайлан, 2026 оны төлөвлөгөөний төсөлтэй танилцав.

Уг асуудлыг 15 цаг 54 минутад хэлэлцэж дуусав.

Дэд хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 51 минут үргэлжилж, 10 гишүүнээс 8 гишүүн хүрэлцэн ирж, 80.0 хувийн ирцтэйгээр 15 цаг 55 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ХҮНИЙ ЭРХИЙН ДЭД ХОРООНЫ
ДАРГА

С.ЭРДЭНЭБОЛД

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ГАЗРЫН
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 12 дугаар сарын 23-ны өдөр, Мягмар гараг
Төрийн ордны “Үндсэн хууль” танхим
15 цаг 04 минут

ХҮНИЙ ЭРХИЙН ДЭД ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

С.Эрдэнэболд: Сайн байцгаана уу? 2025 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаан эхлэхэд бэлэн болсон байна.

Дэд хорооны гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэж байна.

Дэд хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Хүний эрхийн дэд хорооны 2025 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье. /алх цохив/

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7.8-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Сүхбаатарын Эрдэнэболд, Хүрэлбаатарын Баасанжаргал, Баярмагнайн Баярбаатар, Пүрэвжавын Сайнзориг, Лхагвасүрэнгийн Соронзонболд, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин нар ирсэн.

Дөнгөж сая санал хураалттай байсан. Г.Уянгахишиг гишүүн, О.Номинчимэг гишүүн, Ж.Баярмаа гишүүн гурав одоо орж ирнэ. Ингээд үндсэндээ 54.5 хувийн ирцтэй учраас дэд хорооны ирц бүрдсэнийг мэдэгдэж байна.

Хэлэлцэх 3 асуудал байгаа.

Нэгдүгээрт, Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль болон Гамшгаас хамгаалах тухай хуулийн хүний эрхийн хэрэгжилтийн талаарх үнэлгээтэй танилцана.

Хоёрдугаарт, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцын хэрэгжилтийг сайжруулж, зарим шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх тухай санал, зөвлөмж Х.Баасанжаргал гишүүний санаачилгаар хэлэлцэх асуудлын жагсаалтад орж байгаа.

Гуравдугаарт, Хүний эрхийн дэд хорооны 2025 оны үйл ажиллагааны тайлан бөгөөд 2026 оны төлөвлөгөөний төсөлтэй танилцана.

Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүн байна уу? Алга байна.

Эхний асуудал.

**Нэг.Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль болон
Гамшгаас хамгаалах тухай хуулийн хүний эрхийн хэрэгжилтийн талаарх
үнэлгээтэй танилцах асуудал**

Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль болон Гамшгаас хамгаалах тухай хуулийн хүний эрхийн хэрэгжилтийн талаарх үнэлгээтэй танилцъя.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танхимд урья.

Хүний эрхийн дэд хорооны 2025 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанд Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль болон Гамшгаас хамгаалах тухай хуулийн хүний эрхийн хэрэгжилтийн талаарх үнэлгээтэй танилцахаар нэгдүгээр хэлэлцэх асуудалд батлагдсан байгаа.

С.Эрдэнэболд: Үүнтэй холбогдуулж ажлын хэсгийг Та бүхэнд танилцуулъя.

С.Дондов Хүний эрхийн Үндэсний комиссын Хүний эрх хамгаалагчийн асуудал хариуцсан гишүүн, Р.Рэнцэндулам Хүний эрхийн Үндэсний комиссын референт, Ш.Ариунаа Монголын эмэгтэйчүүдийн хөдөлмөрийг дэмжих холбооны тэргүүн, Г.Сүхбат Монголын Эмнести Интернэйшнлийн өсөлт, хөгжил хариуцсан зохицуулагч, У.Мандхайцэцэн Хүний эрхийн хөгжил төвийн гүйцэтгэх захирал, Г.Уранцоож Хүний эрх, хөгжил төвийн тэргүүн, Б.Навчаа Дорноговь аймгийн Хатанбулаг сумаас төлөөлж оролцож байна. Ц.Баттулга Дорноговь аймгийн Хатанбулаг сумаас төлөөлж оролцож байна. Баярсайхан Дорноговь аймгийн Хатанбулаг сумаас төлөөлж оролцож байгаа. Ө.Оюунцэцэг Дорноговь аймгийн Даланжаргалан сумаас төлөөлөн оролцож байна. Д.Гантөр Дорноговь аймгийн Улаанбадрах сумаас төлөөлөн оролцож байна. Д.Хишигт Дорноговь аймгийн Баяндун сумаас төлөөлөн оролцож байна. Г.Сүхбаатар Өвөрхангай аймгийн Арвайхээр сумаас төлөөлөн оролцож байгаа юм.

Хүний эрхийн дэд хороо хүний эрхийн форумтай хийх 8 уулзалтыг өнөөдрийн байдлаар дэд хорооны хурлаар хамтатган хийсэн байгаа.

Өнөөдрийн уулзалтаар 2 илтгэлийг сонсоно.

Ингээд эхний илтгэлийг Дорноговь аймгийн Хатанбулаг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга Б.Навчаа “Монгол Улсын зарим хууль, арга хэмжээний төлөвлөгөөний тодорхой зүйл, заалтын хэрэгжилтийг

үнэлэх, орон нутгийн иргэдийн үнэлгээний тухай товч танилцуулга болон Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.6 дахь заалтын хэрэгжилт” сэдвээр илтгэл тавина.

Индэрт урья. Танилцуулах хугацаа 10 минут.

Улсын Их Хурлын гишүүдэд танилцуулга тарсан байгаа.

Тийм учраас Та шууд илтгэлээ тавиад явж болно.

Б.Навчаа: Энд хүрэлцэн ирсэн Та бүхэндээ энэхүү өдрийн мэндийг хүргэе.

Тэгээд Дорноговь аймгийн Хатанбулаг сумаас иргэдийн төлөөлөл болон Хүний эрхийн дэд хорооны хуралдаанд оролцож байгаадаа баяртай байна.

Хүний эрхийг хамгаалах чухал ач холбогдолтой Монгол Улсын зарим хууль, арга хэмжээний төлөвлөгөөний тодорхой зүйл, заалтын хэрэгжилтийг үнэлэх зорилготой судалгааг 2025 оны 10-аас 11 дүгээр сард Өвөрхангай аймгийн төв, Дорнод аймгийн Баяндун сум, Дорноговь аймгийн Даланжаргалан, Улаанбадрах, Хатанбулаг сум гээд 3 аймгийн 5 сумын нийт төрийн 44 байгууллага, хувийн хэвшлийн 29 аж ахуй нэгж, нийт 73 байгууллагаас судалгааг авсан.

Хүний эрхийг хамгаалах эрх зүйн байдлын тухай хууль 2021 оны 4 сард батлагдаад 2021 оныхоо 7 сарын 01-нээс хэрэгжиж эхэлсэн хууль.

Тэгээд судалгааныхаа нэгдүгээр асуудал “Хүний эрх хамгаалагчийн үйлдлийг хамгаалах зохицуулалтыг байгууллагын дотоод журамд тусгаж хэрэгжүүлэх сургалт зохион байгуулах” гэсэн асуулт байсан.

Энэ асуултын хүрээнд ерөнхийдөө 6 асуудал дээр бид судалгаа авсан. Тэгээд 3 аймгийн 5 сумынхаа судалгааг нэгтгэсэн.

Тэгээд Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийг төрийн 44 байгууллагаас авсан.

■ Үүнийг хэрэгжүүлдэг үү гэсэн асуултад –

— “Тийм” гэсэн 21,
— “Үгүй” гэсэн 23.

■ Тухайн байгууллага хүний эрхийн 9.1.6 дахь заалтыг хэрэгжүүлдэг үү гэсэн асуултад –

— “Тийм” гэсэн 18,
— “Үгүй” гэсэн 16.

- Заалтыг хэрэгжүүлэх тухай байгууллагынхаа дотоод журамд тусгасан уу гэсэн асуултад –

— “Тийм” гэсэн 17,
— “Үгүй” гэсэн 18.

- Сургалт зохион байгуулдаг уу гэсэн асуултад –

— “Тийм” гэсэн 15,
— “Үгүй” гэсэн 19.

Байгууллагынхаа дотоод журмыг нь бид газар дээр нь үзэж танилцах дээр үзүүлсэн нь ерөнхийдөө ийм байгаа.

- Дотоод журамдаа тусгасан гэдэг дээр

— “Тийм” гэсэн 10,
— “Үгүй” гэсэн 13 байгаа.

- Энэ асуудлаар сургалт, зөвлөгөө авах хэрэгтэй юу гэдэг дээр –

— “Тийм” гэсэн 39,
— “Үгүй” гэсэн 5 төрийн байгууллага судалгаанд өгсөн байна.

Бид 3 аймгийн 5 сумын 29 хувийн хэвшлээс авсан байгаа.

Тэгээд нэгдүгээр асуудал дээр –

— “Тийм” гэсэн 16,
— “Үгүй” гэсэн 11.

Хоёр дахь нь танай байгууллага 9.1.6-г хэрэгжүүлдэг үү гэдэг дээр –

— “Тийм” гэсэн 13,
— “Үгүй” гэсэн 11.

Дотоод журамдаа тусгадаг уу гэдэг дээр адилхан

— “Тийм” гэсэн 12,
— “Үгүй” гэсэн 12-ыг өгсөн өгсөн байна.

Сургалт хийдэг үү гэдэг дээр –

— “Тийм” гэсэн 11,
— “Үгүй” гэсэн 13 гэсэн байна.

Дотоод журам дээр нь ерөнхийдөө 6 байгууллага дотоод журамдаа заасныг ингэж бид нарт зураг хөргөөрөө үзүүлсэн байна.

16 байгууллага үзүүлэх боломжгүй ээ гээд үзүүлээгүй байна.

Сургалт хэрэгтэй юу гэдэг дээр хувийн хэвшлүүд 27 сургалт авах шаардлагатай. 1 байгууллага бид сургалт авах шаардлагагүй ээ гэсэн байна.

Ерөнхийдөө судалгааны дүнг яг өөрөө хариуцаж зохион байгуулсан хүний хувьд дүгнэхэд хүний эрхийг хангах, хамгаалах талаар тухайн байгууллагын дотоод журамдаа **“Нийгмийн баталгааг хангах”** хөтөлбөр дээр тодорхой хэмжээний заалт оруулж өгсөн байгаа.

Энэ судалгааны 9.1.6 дахь асуудал хүний эрх зүйн байдлыг яаж хамгаалж байна гэдэг дээр яг байгууллагын дотоод журам дээр тусгаж өгсөн заалт ховор. Энэ хуулийг хөдөө орон нутагт ихэнхдээ хуулийн заалтыг мэдэхгүй байна.

Тийм учраас **“хүний эрх хамгаалагч”** гэдэг яг хэн байх талаар ойлголт хаана хаанаа дутмаг байна. Тийм учраас энэ хуулийн хэрэгжилт дутмаг байна гэж байгаа юм.

Тэгээд ерөнхийдөө энэ завшааныг ашиглаад орон нутагт хүний эрхийг хэрхэн зөрчигдөж байгаа тал дээр би хоёр асуудал дээр ярьж гэж бодож байгаа юм.

Нэгдүгээрт нь, төрийн албан хаагч нар үзэл бодлоо илэрхийлэх, үгээ хэлэх эрх нь хязгаарлагдмал байна гэдгийг олон жил орон нутагт ажилласан байгууллагын хувьд ингэж байгаа.

Улсын Их Хурлын гишүүд очоод, аймаг, сумын удирдлагууд очоод хурал зөвлөгөөн хийхээр төрийн албан хаагчдыг сумын Засаг дарга нь байгууллагуудынхаа дарга нартай албан ёсоор тэнд очоод суулгадаг. Тэгээд Та бүхэн мэдэж байгаа байх. Тийм ээ. Тэгээд төрийн албан хаагч нар тэнд үгээ хэлж, үзэл бодлоо илэрхийлж байна уу гэхээр дугарч байгаа хүн байдаггүй. Сумд очиход хоёр, гурван хүн малчдын төлөөлөл юм уу, иргэдийн төлөөлөл хоёр, гурван хүн үгээ хэлдэг.

Тийм учраас тэнд хязгаарлагдмал байна. Нөгөө талаасаа байгууллагынхаа удирдлагаас айдаг юм уу, янз бүрийн шалтгаанаар төрийн албан хаагчид болж бүтэхгүй асар их ажлын ачааллын дарамт их байна. Тэрийгээ илэрхийлж чадахгүй. Иймэрхүү байдал үүсээд байгаа юм.

Тэгээд хоёр дахь нь сумын татварын орлогоос. Одоо манай Хатанбулаг сумын хувьд өөрөө өөрийгөө санхүүжүүлдэг. Аймгийн татаас төвлөрүүлдэг сум байгаа.

Тэгээд сумын татварын орлогоос 70 гаруй хувийг аймагт татаас гэж авч байгаа нь сум орон нутаг бие дааж хөгжих боломжийг хязгаарлаж байгаа. Энэ нь эргээд хүний эрхтэй холбоотой тухайн орон нутгийн иргэдийн эрх ашиг зөрчилдөж байна гэж үзэж байгаа юм.

Жишээлбэл, Та бүхэнд тараасан материал дээр би 2025, 2026 оныхоо орлогыг орон нутагт ийм байна гэдгийг тавьж өгч байгаа юм.

Хатанбулаг сум гэх гээд 2025 онд 7.9 тэрбум төгрөгийн орлого олсон байхад аймгийн төсөвт татан төвлөрүүлэх орлого нь 5.6 төгрөг болж байгаа юм. Цалингийн зардал нь 1.2 тэрбум төгрөг. Орон нутгийн хөгжлийн сан дээр 1 тэрбум төгрөг гээд. Ингээд нэг ёсондоо уг нь төсвийн тухай хуулиараа суманд орох татварыг нь, аймагт орох татварыг нь, улсад орох татварыг нь хуульчлаад заагаад өгсөн байгаа юм.

Тэгээд сум 7.9 тэрбум төгрөг олоод 5.6 тэрбумыг нь шууд аймаг руугаа татаас гээд аймгаасаа цаанаа төсөв батлахдаа заагаад өгчхөж байгаа юм. Ингээд дүгнээд үзэхэд төрийн албан хаагч нар өнөөдөр ерөнхийдөө цалингаа аваад өөр бусад үйл ажиллагаагаа хийх боломж нөхцөл нь муу байгаа юм.

Жишээлбэл, эмнэлэг дээр очоод л бид иргэдийн хурал гээд л очоод хяналт шалгалт хийгээд л, иргэдтэйгээ уулзаад л явуулахаар эмнэлэг дээр очиход л тарианых нь өөрөө хүйтэн, хүмүүс очоод тариагаа хийлгэхдээ чичирч суугаад л өвлийнхөө хувцастай хувцастай тариагаа хийлгээд л явж байгаа юм. Дотуур байранд очлоо гэхэд камергүй байгаа юм.

Манай суман дээр уул уурхай хөгжөөд мал маллах сүүлдээ залуу малчид их ховор болоод, малжуулах төсөл хэрэгжүүлье гэхээр нөгөө мөнгө нь байхгүй.

Уг нь 2023, 2024 онд жишээлбэл 4 тэрбум төгрөг сум ордог байхад 1 тэрбум төгрөгийг нь аймагт татаас гээд авдаг байсан юм. Тэгээд 2025 оноос ийм боллоо. 2026 он дээр манай хурал төсвөө баталсан. 8.3 тэрбум төгрөгийн орлого олж байтал 6.1 турбумыг нь татаасанд авчхаж байгаа байхгүй юу. Тэгээд 1.2 тэрбум нь цалиндаа яваад. Орон нутгийн хөгжлийн сан дээр 800 төгрөг.

Тэгээд Засаг даргаас мөрийн хөтөлбөрөө хэрэгжүүлэх ажлууд дээр нь мөнгө тавих ямар ч боломжгүй ийм болчихоод. Тэгээд иргэд, төр хоёрын энэ дундаас чинь үүсэж байгаа байхгүй юу.

Орон нутгийнхаа байгууллагад иргэдээс багийн иргэдийн хурлаараа яваад саналаа аваад 2026 оны төсөв төлөвлөгөөнд тусгах ямар ажил байна, байгууллагууд дээр юу байна гээд саналаа авчхаад хуралд оруулаад юугаа хийхээр нөгөө төсөв нь татаасдаа явсан. Тэгээд орон нутагт орон нутагт ийм байдал, хүний эрх нэг ёсондоо зөрчигдөж байна.

Дээрээс нь төрийн албан хаагч нар ерөөсөө үгээ хэлэх эрх нь хязгаарлагдсан, захиргааны хэдэн албан хаагч нар аймаг, сумаас очиж байгаа тайлан мэдээний хариутай бичгийн хариуг явах, тайлан мэдээн дээр нэг хийсэн гэсэн иймэрхүү байдлаар хандаад, яг орон нутгийнхаа нөхцөл байдал дээр төсөв нь ч нэг талаасаа байхгүй. Дээрээс нь төрийн албан хаагч нар өөрсдөө үзэл бодлоо илэрхийлж чадахгүй учраас иймэрхүү байдалтай байна.

Тэгээд ерөнхийдөө энэ хуулийг цаашид хэрэгжүүлэхэд бид юу анхаарах вэ гэдэг дээр нэг хэдхэн зүйл хэлье гэж санаж байна.

Хуулийн талаар иргэд, байгууллага, аж ахуйн нэгжүүдэд зөв ойлголтыг өгөх. Зөвхөн хүний эрх хангах чиглэлээр байгаа болохоос биш хүний эрх хамгаалагчийг эрх зүйн байдлыг энэ дээр хаа хаанаа анхаарахгүй байна.

Төрийн бүх шатны байгууллагууд хуулийн хэрэгжилтийг сайжруулах, үйл ажиллагааны төлөвлөгөө, хөтөлбөрт тусган хэрэгжүүлэх, тайлагнадаг баймаар байна.

Хүний эрхийн эрх зүйн байдлын тухай хуулийн сургалтыг шат шатдаа зохион байгуулах шаардлагатай байна гэж үзэж байгаа юм. Орон нутгийн хүний эрхийн төлөв байдлын тайлан хэлэлцдэг Хүний эрхийг хангах үндэсний хороо гэдгийг татан буулгасан. Мөн энэ чиг үүргийг Үндэсний бүтээмжийн хороонд хариуцуулсан боловч энэ хороог татан буулгачхаад энэ чиг үүргийн хэрэгжилт хангагдахгүй байдал үүсчхээд байгаа юм. Уг нь энэ орон нутгийн Хүний эрхийн төлөв байдлын тайланг хэлэлцдэг хороотой байсан.

Энэ чиг үүрэг хариуцах эзэнгүй болсон учраас үүнийг цаашдаа үүнийг хариуцах эзэнтэй болгож өгөх гэдэг иймэрхүү саналуудыг тавьж байна. Баярлалаа.

С.Эрдэнэболд: Дорноговь аймгийн Хатанбулаг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга Б.Чимгээ хуулийн хэрэгжилттэй холбоотой танилцуулга хийлээ.

Хоёр дахь танилцуулга явсны араас Улсын Их Хурлын гишүүд саяын тавигдсан хоёр танилцуулгаас асуулт асуух, хариулт авах дэг байгаа.

Ингээд хоёр дахь илтгэлийг Дорнод аймгийн Баяндун сумын Мөнгөн хуримтлалын бүлгүүдийн холбооны удирдах зөвлөлийн гишүүн Дорнод аймгийн Хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал эрхэлсэн мэргэжилтэн Д.Хишигт Гамшгаас хамгаалах тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.2, 51.4 дэх заалтын хэрэгжилтийн талаар танилцуулга, илтгэл тавина. 10 минут.

Д.Хишигт: Сайн байцгаана уу? Дорнод аймгийн Баяндун сумын Мөнгөн хуримтлалын бүлгүүдийн холбооны удирдах зөвлөлийн гишүүн Д.Хишигт байна.

Бид бүхэн энэ “Форум Ази”, “Хүний эрх хөгжил” төвтэй Баяндун сумын Мөнгөн хуримтлуудын бүлгүүдийн холбоо хамтарч энэ судалгааг зохион байгуулсан байдаг.

Ерөнхийдөө Мөнгөн хуримтлалуудын бүлгүүдийн холбоо 2009 оноос хойш Дорнод аймагтаа анхдагч болж 9 бүлэгтэйгээр үйл ажиллагаа явуулж байгаа.

Ер нь агуулгын хүрээнд түрүүн ер нь агуулга ижил. Монгол Улсын зарим хууль арга хэмжээний төлөвлөгөөний тодорхой зүйл, заалтын хэрэгжилтийг үнэлэх, орон нутгийн иргэдийн санаачилгыг дэмжих агуулгын хүрээнд Гамшгаас хамгаалах хууль бодлогын хэрэгжилтийн үнэлгээний дүнг танилцуулахаар зэхсэн байгаа.

Уг хамрах хүрээнд 3 аймгийн 5 сум, нийт төсвийн 44 байгууллага, 29 аж ахуй нэгж тухайн үнэлгээнд хамрагдсан байдаг.

Хуулийн заалтын хувьд гамшгаас хамгаалах эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардал Гамшгаас хамгаалах тухай хуулийн 51.2 дугаар зүйл, заалт болж ордог. Үүн дээр асуултуудыг байгууллагуудаас авсан байгаа.

Мөн энэ хуулийн 51.4 дээр улсын хэмжээнд гамшгаас хамгаалах төвлөрсөн арга хэмжээний зардлыг улсын төсвөөс, мөн орон нутгийн төсвөөс нийслэл, сум, дүүргийн зардлыг санхүүжүүлдэг байгаа.

Мөн төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдэд зардлаа өөрөө хариуцна гэж заасан байдаг. Энэ дээр бид энэ 2 хуулийн заалтыг юунд оруулсан юм бэ гэхээр 51.2 дахь заалтдаа “дүүрэг, төрийн байгууллага болон тухайн жилийн төсвийнхөө 1 хувиас доошгүйг зарцуулахаар тооцон төсөвт тусгаж” гээд оруулсан мөртлөө арынхаа хууль дээр болохоороо “төрийн болон нутгийн захиргааны байгууллага нь зардлаа өөрөө хариуцна” гээд заасан байдаг.

Энэ зөрчилтэй харагдаж байна уу гэдэг дээр санал болгох үүднээс энэ хоёр заалтыг оруулсан байгаа.

➔ Гамшгаас хамгаалах тухай хуулийн 51.2 дугаар зүйл, заалтаар төрийн 44 байгууллагаас судалгаа авахад танай байгууллага Гамшгаас хамгаалах тухай хуулийн дагуу 1 хувийг хувиас доошгүйг зарцуулахаар төсөв тусгадаг уу гэдэг асуултад

— “тийм” гэсэн 16 байгууллага,
— “үгүй” гэсэн 24 байгууллага.

➔ Танай байгууллага 2025 онд жилийн төсвийн хэдэн хувьтай тэнцэх хэдэн төгрөгийг гамшгийн эрсдэлийг буулгахад төсөвлөсөн бэ гэдэг дээр

- “тийм” гэсэн 3 байгууллага,
- “үгүй” гэсэн 19 байгууллага.

→ 2024 оны төсвийг зарцуулах гүйцэтгэлийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн тайлан ил тод байдаг уу гэдэг асуултад

- “тийм” гэсэн 10 байгууллага,
- “үгүй” гэсэн 17 байгууллага.

→ Төсөв зарцуулах төлөвлөгөөнд олон нийтийн санал авдаг уу гэдэг асуултад

- “тийм” гэдэг дээр 9 байгууллага,
- “үгүй” гэдэг дээр 21 байгууллага хариулсан байна.

29 аж ахуйн нэгж, байгууллагаас дээрх 4 асуултаар судалгаа авахад

■ Нэгдүгээр асуултад –

- “тийм” гэсэн 18 байгууллага,
- “үгүй” гэсэн 9 хувийн хэвшлийн байгууллага.

■ Хоёрдугаар асуултад

- “тийм” гэсэн 18 байгууллага,
- “үгүй” гэсэн 12 байгууллага.

■ Гуравдугаар асуултад

- “тийм” гэсэн 16 байгууллага,
- “үгүй” гэсэн 10 байгууллага.

■ Дөрөвдүгээр асуултад

- “тийм” гэсэн 12 байгууллага,
- “үгүй” гэсэн 13 байгууллага гэж хариулсан байгаа.

Энэ асуулт асуултын асуулга, тайлбараар байгууллагуудаас тайлбар авсан байдаг. Энэ дээр зөвхөн 2-хон суман дээр 44 байгууллагын ерөөсөө 2-хон байгууллага нь төсөвтөө 28.5 сая төгрөгийг тавьж шийдвэрлүүлсэн. Бусад байгууллага ерөөсөө төсөвтөө тусгаагүй гэсэн хариултыг өгсөн байгаа.

Ерөнхийдөө сумын засаг даргын нөөцийн санд уг гамшгаас хамгаалах зардлыг хуваарилах маягаар зарцуулдаг. Гэсэн хэдий боловч энэ нь бүрэн зарцуулагддаггүй гэсэн тоон дүн гарч байгаа.

2024 оны төсвийг зарцуулах төлөвлөгөө, гүйцэтгэлийн тайлан ил тод байдаг уу гэдэг дээр мөн 2 сум ил тод байдаг. Шилэн дансны хуулиар ил тод тавигдсан байдаг гэсэн хариултыг өгсөн байгаа.

Мөн төсөв зарцуулах төлөвлөгөөнд олон нийтийн санал авдаг уу гэдэг дээр төрийн байгууллагууд нь төсвийн төсөөлөл болон Сангийн яаманд хүргүүлж байгаа өөрсдийн төсвийн төсөөлөлдөө уг зардлыг жил бүр тусгадаг боловч санхүү шийдэгддэггүй ээ гэсэн хариултыг өгсөн байгаа.

Эндээс бид дүгнэхэд юу гэж дүгнэсэн бэ гэхээр төрийн байгууллагуудын төсвийн төсөөллийг хийхдээ 1 хувийг гамшгаас хамгаалах зардалд тусгаад явуулдаг боловчиг аймгийн Төрийн сангийн хэлтэс болоод Сангийн яамнаас батлагдаагүй гээд хассан байгууллага 30 байна гэж хариулт өгсөн байдаг.

Мөн гамшгаас хамгаалах төлөвлөгөөний дагуу төсөвлөөд Тамгын газар нь Засаг даргын нөөцийг нь дандаа тусгуулж батлуулдаг боловчиг мөн 2-хон сум 25.8 сая төгрөг гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд зарцуулна гээд 2025 онд зарцуулагдсан байна.

Тэгэхээр 44 байгууллагын 2-хон сум гэхээр тун хангалтгүй тоон дүн гарч байна. Эндээс.

Бид бүхэн Шилэн дансны хуулиар ил тод нийтэд тайлагнаж байгаа **shilendans.gov.mn**-д байршуулсан зардлыг аваад үзэхээр ганцхан шатахууны зардал гэсэн зардал орсон байгаа. Бусад зардал гээд хүмүүсийн тухайн өдөр нь гамшигт ажилласан зардал болон бусад зардлууд энэ дээр тооцогдсон дүн алга байна гэж харагдсан.

Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд төсвөө өөрсдийнхөө орлогод шууд зардлаа гаргаад явдаг гэсэн тайлбарыг хэлсэн байдаг.

Дүгнэлтийн хувьд энэ хуулийн заалт орон нутагт хэрэгжихгүй байна. Тухайн шатын төрийн байгууллагууд шат шатны төрийн байгууллагууд энэ 1 хувиа авна гэж ямар ч байгууллагууд шаарддаггүй. Иргэдэд ч энэ хуулийн заалтыг мэддэггүй. Тухайн мэдээлэл нь иргэнд хүрдэггүй. Тэдний оролцоо хангагдахгүй байна гэж үзэж байна.

Мөн орон нутагт гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх, хамгаалах, хохирлыг даван туулах төлөвлөгөө байхгүй байна гэдэг давамгайл байгууллагуудын хариулт дээр байгаа.

Зөвлөмжийн хувьд тухайн 51.2 дахь заалтыг хэрэгжүүлэхээс гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх, хохирол багатай, дарамт болох хэрэгцээг бодитойгоор төсөвлөөд төлөвлөгөөнд тусган санхүүжүүлж, ил тод тайлагнадаг болох шаардлагатай байна.

Сум бүр иргэдийн оролцоог хангасан гамшгаас хамгаалах төлөвлөгөөг хэрэгжүүлж, үнэлгээг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралдаа тайлагнадаг болмоор байна гэсэн зөвлөмжийг бид бүхэн гаргаад байна.

Тэгэхээр энэ хууль дээр үнэхээр энэ төсөв байдаг бол хүний эрх зөрчигдөх нь бага. Тухайн гамшгаас хамгаалах дээр хувцастай, хувцасгүй, нүцгэн, нойтон ямар ч техник нь шаардлага хангахгүй хуучирсан техниктэй. энэ үйл ажиллагаанд хүмүүс дайчлагдаж байна гэдгийг хамгийн сүүлд хэлье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

С.Эрдэнэболд: Баярлалаа. Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль болон Гамшгаас хамгаалах тухай хуулийн хүний эрхийн хэрэгжилтийн талаарх дүгнэлттэй холбогдуулж орон нутгаас 2 эрх бүхий албан тушаалтан танилцуулга, илтгэл тавилаа.

Илтгэлтэй холбогдуулж дэгээрээ асуулт, үгийг нэгтгэж байгаа. Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, үгтэй гишүүд нэрсээ өгнө үү.

Х.Баасанжаргал гишүүнээр тасаллаа. Х.Баасанжаргал гишүүний микрофоныг нээе.

Х.Баасанжаргал: Юуны өмнө одоо манай 8 дахь удаагийн хурал. Тийм ээ. Манай Хүний эрхийн форумтай хамтарч хийж байгаа.

Тэгээд манай Хүний эрхийн дэд хороо анх удаагаа Хүний эрхийн форумтай хийж байгаа уулзалтыг илүү тогтмолжуулаад, цаашид илүү үүнийг үр нөлөөтэй, үр дүн гардаг, тэгээд илүү механизм байх тал дээр манай дэд хороо ч гэсэн цаашид анхаараад ажиллана.

Тэгээд манай орон нутгаас ирсэн орон нутгийнхандаа онцгойлон талархлаа илэрхийлье.

Тэгээд Та бүхэн яг энэ асуудалдаа анхаарлаа хандуулаад, өөрсдөө судалгаа хийгээд, тэр дундаа тэр сонгосон сэдэв миний аягүй анхаарлыг татаж байна.

Ялангуяа гамшгаас хамгаалахтай холбоотой зардал, төсвийн асуудлыг ингэж олж хараад энэ дээр ингэж анхаарал тавьж байгаад их талархах ёстой аяг чухал сэдвийн нэг.

Одоо Засгийн газар дээр Гамшгаас хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулга төсөл нь ид яригдаад, судалгаа, мэдээллүүдээ нэгтгээд явж байгаа. Тэгээд Та бүхний хийсэн судалгаа, мэдээллийг бид дэд хороогоороо дамжуулаад Засгийн газрын холбогдох албан тушаалтнуудад хүргүүлэх ёстой гэдэг зүйл байна.

Хоёр дахь гол асуух асуулт байна. Хүний эрх хамгаалагчийн тухай хууль дээр ялангуяа С.Дондов гишүүн хариулах болов уу.

- Хүний эрх хамгаалагчийн энэ механизм өөрөө үр дүн хэр ажиллаж байгаа гэж Та бүхэн харж байгаа вэ?
- Ямар бэрхшээл ямар асуудал тулгамдаад байгаа вэ?

Илүү өргөн хүрээнд ажиллах хэрэгцээ шаардлага байгаа гэж харж байгаа. Би өөрөө хамгийн анхны хүний эрхийн хамгаалагчийн хорооны гишүүн байсан.

Тэгэхээр энэ хуулийг яаж илүү өргөн хүрээг хамруулах вэ энэ дээр хэний оролцоо илүү дутагдаад байна вэ гэдэг талаас нь Та саналаа хэлээч ээ гэж хүсэж байгаа. Тэгээд аягүй чухал үндэсний механизм байгаа. Тийм ээ.

Гамшгаас хамгаалах тухай хууль дээр нэг асуулт байна. Гамшгаас хамгаалахтай холбоотой зардлуудыг аж ахуйн нэгжүүд төрийн байгууллагууд төсөв дээрээ суулгаад өгөхөөр батлагддаггүй гэж би ойлголоо. Зөв үү? Аудитын газраас янз бүрийн үүнтэй холбоотой санал дүгнэлт авч байсан уу?

Хоёрдугаарт, аж ахуй нэгж өөрийнхөө төсөв дээр яг энэ гамшгаас хамгаалах тодорхой хэмжээний мөнгө төсөвлөхөөр татвараас хасагдах зардалд нь тооцогддог юм болов уу, яадаг юм гээд хоёр асуулт байна.

С.Эрдэнэболд: Хүний эрхийн Үндэсний комиссын Хүний эрх хамгаалагчийн асуудал хариуцсан гишүүн С.Дондов хариулна.

Индрээс хариулъя.

С.Дондов: Хүний эрхийн дэд хороо хүний эрхийн хамгаалагчийн асуудалд анхаарал хандуулаад, орон нутгийн хийсэн судалгааг танилцаад, мөн Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилтийн талаар ингэж анхаарч байгаа явдалд их талархаж байна.

Хүний эрхийн хамгаалагчийн асуудал эрхэлсэн гишүүнээр би 2022 оны 6 сард томилогдсон. Энэ цагаас хойш Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасан хүний эрх хамгаалагчийн эрх зөрчигдсөн эсэх талаар дүгнэлт гаргах чиг үүргийг хэрэгжүүлж байна.

Хоёрдугаарт, Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуульд хүний эрх хамгаалагчийн үйл ажиллагааг –

- “дэмжих”,
- “хамтран ажиллах”,
- “нээлттэй байх”

-гэсэн агуулга бүхий заалтыг дотоод журамдаа төрийн байгууллага болон хуулийн этгээд, ашгийн бус байгууллага оруулна гэсэн заалт байгаа юм.

Тийм учраас Хүний эрхийн Үндэсний комиссоос бид аргачлалыг дэмжлэг болгох зорилгоор бий болгосон. Үүнийгээ бид Хүний эрхийн дээд комиссарын газартай нэлээн нягт ажиллаад, тэд нарын зөвлөгөө, дэмжлэгийг аваад энэ аргачлалыг боловсруулсан.

Энэ аргачлалыг боловсруулсны дараа би Төрийн албаны зөвлөлөөс төрийн алба, төрийн байгууллага дотоод хэм хэмжээндээ яаж оруулбал зохилтой юм бэ гэдэг талаар нэлээн анхаарч байгаад хуулийн этгээдэд оруулах аргачлал, төрийн байгууллагын дотоод хэм хэмжээнд оруулах аргачлал гэсэн хоёр аргачлалыг батлаад Төрийн албаны зөвлөлд албан ёсоор хүлээлгэж өгөөд төрийн байгууллагадаа Та бүхэн үүнийг хэрэгжүүлээрэй, хуулийн этгээд, ашгийн бус байгууллагад бид өөрсдөө сурталчлаад өөрсдөө дотоод хэмжээнд нь оруулах ажлыг ингэж хийнэ ээ гээд энэ ажил тодорхой хэмжээнд үр дүнтэй байгаа гэж ингэж бодож байна.

Хүний эрх хамгаалагчийн эрх зөрчигдсөн эсэх асуудлаар дүгнэлт гаргах асуудал дээр хүний эрхийн хамгаалагчид нэлээн олон төрөл байдаг. Үгээ хэлж, үзэл бодлоо илэрхийлсэн шударга шүүмжлэгчид байна.

Мөн наана нь иргэний нийгмийн байгууллага, үйлдвэрчний эвлэлийн байгууллага, сэтгүүлчид, өмгөөлөгчид гэх мэтийн хүний эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа хүмүүст ихээхэн хүндрэл бэрхшээл учрах, үйл ажиллагааг нь явуулахад айлган сүрдүүлэх, дарамтлах, зарим тохиолдолд үйл ажиллагааг нь хэвийн явуулахад саад учруулах хүртэл нөхцөл байдлууд нэлээн илэрдэг.

Энэ дагуугаа зарим нь гомдол гаргадаг, зарим нь гишүүний санаачилгаар энэ дээр асуудал үүсгэж анхаарахгүй болохгүй нь гэсэн энэ асуудлууд дээр анхаарч ажиллаж байна.

Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасны дагуу орон тооны бус хороо ажиллаж байгаа. Орон тооны бус хороо улирал тутам заавал хуулиараа хуралдах ёстой.

- Улирал тутамдаа хуралдаад, ирсэн гомдлыг хэлэлцээд, дүгнэлтийг хэрхэн яаж гаргах вэ,
- хүний эрх хамгаалагчийн эрхийг ямар хэлбэрээр зөрчсөн юм,
- зөрчсөн албан хаагчид нь ямар хариуцлага оногдуулах юм,
- Хүний эрхийн Үндэсний комиссын эрх хэмжээнд ямар байгаа юм,
- тэр байгууллага өөрөө ямар арга хэмжээ авбал зохилтой юм

-гэх маягаар шаардлага зөвлөмжүүдийг өгөөд явж байна.

Бидний дүгнэлт гаргасан хэсгүүдээс би тоймлон хэлэх юм бол иргэний нийгмийн байгууллагуудаас байгаль орчны асуудлаар ажилладаг олон хүмүүс ханддаг. Мөн сэтгүүлчдээс жишээлбэл Н.Өнөрцэцэг сэтгүүлчид бид хүний эрхийн талаас нь дүгнэлт гаргасан.

Мөн н.Баярмаа гээд сэтгүүлч мөн гаргасан.

Сэтгүүлчдийн асуудлаар бид гэмт хэрэгтэй холбогдуулаад байгаа тохиолдолд энэ хамаарахгүй шүү дээ танайд гэдэг хэдий ч процессын явцад, мөн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, нийтийн мэдэх эрхийг хангаж байгаа сэтгүүлчийн үйл ажиллагаа хэвийн явах ёстой, шударга байх ёстой гэсэн агуулгаар нь дүгнэлтүүдийг гаргаж байсан.

Мөн төрийн байгууллагаас н.Сийлэгмаа буюу сангийн зохицуулалт буруугаас надыг ажилгүй болголоо. Би амьдрал ахуй хүнд байна энэ тэр гэсэн ийм гомдлууд гарсны дагуу Боловсролын яаманд тодорхой хэмжээний шалгалт хийсэн.

Мөн тодорхой хэмжээний зөвлөмж, шаардлагуудыг явуулж байсан.

Өмгөөлөгчдийн хувьд өнгөрсөн жилийн илтгэлүүдэд манайд гаргаж байгаа гомдлын нөхцөл байдал, хүний эрх хамгаалагчдын өнөөгийн нөхцөл байдлыг үнэлж үзээд энэ жил яг энэ асуудлаар Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, илтгэлээ явуулах... /минут дуусав/

С.Эрдэнэболд: 1 минут сунгая.

С.Дондов: ... тодорхой дурдаж өгөөд, тэгээд Улсын Их Хурлаас гаргасан тогтоол хамгийн чухал байдаг.

Би үүнээс нэг хэрэгжихгүй байгаа тогтоолын талаар товчхон хэлээд өндөрлөө гэж бодож байна.

→ Гэрч, хохирогч, хүний эрхийн хамгаалагч, шүгэл үлээгчийн аюулгүй байдлыг хангасан бие даасан хараат бус механизмтай Монгол Улс болох ёстой.

Гэтэл Засгийн газрыг шүүмжилчхээд Цагдаагийн ерөнхий газар байгаа гэрч, хохирогчийг хамгаалах хэлтсээр аюулгүй байдлаа хамгаалуулна гэдэг маш түвэгтэй. Тэнд хамгаалах хүсэлт гаргасан хүмүүс ч гэсэн бид нарт эргэж гомдол гаргадаг. Бид аюулгүй байдлаа хамгаалуулахад эргэлзэж байна.

Тийм учраас Та нар бидний аюулгүй байдлыг өөр байдлаар хамгаалж өгөөч ээ гэдэг.

Гэтэл бидний хууль өнөөдөр ямар байна вэ гэхээр Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 5.1-д зааснаар гэрч, хохирогч, хүний эрх хамгаалагч, тэдний гэр бүлийн аюулгүй байдлыг хангах асуудал нь Цагдаагийн ерөнхий газрын Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтэс гэсэн –

- хэдхэн хүнтэй,
- төсвийн хувьд хязгаарлагдмал,
- хүн хүчний хувьд хязгаарлагдмал,
- орон нутагт аюулгүй байдлыг нь хангах боломжгүй түвэгтэй байдал байгаа.

Тийм учраас Тахарын албыг татан буулгахдаа ямар нэгэн үнэлгээ хийгээгүй. Ямар учраас Тахарын алба байх шаардлагагүй юм бэ гэдгийг бодитой үнэлээгүй учраас үр дүн нь одоо хүртэл... /минут дуусав/

С.Эрдэнэболд: Баярлалаа. Х.Баасанжаргал гишүүн тодруулахгүй. Тийм ээ.

Гамшиг дээр асуусан асуултад Д.Хишигт. Дорнод аймгийн хөдөлмөр эрхлэлт халамжийн асуулт эрхэлсэн мэргэжилтэн.

Д.Хишигт: Гамшгаас хамгаалах тухай хууль 2017 оны 2 сард мөрдөгдөж эхэлсэн.

Энэ хууль батлагдсанаас хойш ерөнхийдөө миний сая хэлсэн 2-хон сум ерөөсөө 3 жилийн өмнө төсвөө тавиад эхэлсэн байгаа байхгүй юу. Одоо хэрэгжүүлж эхэлж байна уу гэхээр үгүй. Бусад суманд нь хэрэгжүүлээгүй байгаа юм.

Тэгэхээр аж ахуй нэгж, байгууллагуудын хувьд би зөвхөн сум дээр жишээ авахад 5 уул уурхайн аж ахуй нэгж төсөв, төлөвлөгөөгөө өөрсдөө батлаад, ажилчдаараа хэлэлцүүлээд баталсан байдаг юм байна.

Гэсэн хэдий боловчиг энэ дээр зардал гаргаад ямар нэгэн гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцоод энэ зардлаа буцаагаад өөрт нь олдохгүй ч гэсэн татварын ямар нэгэн хөнгөлөлт ерөөсөө эдлээгүй байгаа. Тийм.

Энэ дээр нэмээд хэллэхэд төсөвт байгууллагууд гамшгаас хамгаалах төлөвлөгөөндөө тусгасан 1 хувийнхаа зардлыг төлөвлөгөөндөө тусгадаг боловч 2017 оноос хэрэгжээгүй.

Төсөвт байгууллагууд бүр тэгж байгаа юм чинь. Ерөөсөө бэлгэдлийн чанартай цаасан дээр байгаа төлөвлөгөө. Үүнийг явуулаад ч яах вэ дээ гэдэг байдалтай ханддаг болсон байна лээ.

С.Эрдэнэболд: Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль болон Гамшгаас хамгаалах тухай хуулийн хүний эрхийн хэрэгжилтийн талаарх үнэлгээтэй холбогдуулж үндсэн хоёр илтгэл тавилаа.

Цаашлаад Хууль зүйн байнгын хороо, Хүний эрхийн дэд хорооны зүгээс Хүний эрхийн Үндэсний комисс хамтраад саяын тайлан, илтгэл дээр дурдагдаж буй шийдлээ хүлээж байгаа асуудлууд дээр хамтарч ажиллах шаардлагатай гэж үзэж байгаа.

Тэгээд баталсан хууль хэрэгжихгүй байгаа, хаана нь ямар алдаа дутагдал гараад, үүнээс үүдэж хүний эрхийн зөрчлийн шалтгаан нөхцөл болж байгаатай холбогдуулаад –

- Засгийн газрын түвшинд байна уу,
- Улсын Их Хурлын түвшинд байна уу,
- орон нутгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн түвшинд байна уу

-гэдэг дээр бид үүнийг мөрөөр нь хөөж ажиллах зайлшгүй шаардлагатай байгаа.

Тэгээд үүнийг албан харилцааны хүрээнд Үндэсний комисс болон бусад энд ирсэн ажлын хэсгийнхээ байгууллагуудтай хамтраад явъя.

Тэгээд өнөөдөр цастай, зам халтиргаатай үед Улаанбаатар хотоо зорьж ирээд Төрийн ордонд Улсын Их Хурлын Хүний эрхийн дэд хорооны тайлан үнэлгээ танилцуулах үйл ажиллагаанд орон нутгаас зорьж ирсэн иргэддээ онцгойлон талархал илэрхийлье.

Дорноговь аймгаас хүрч ирсэн Б.Навчаа, Ц.Баттулга, А.Баярсайхан, Ө.Оюунцэцэг, Д.Гантөр болон Дорнод аймгаас Д.Хишигт Өвөрхангай аймгаас Г.Сүхбаатар нарын орон нутгаас иргэдийн төлөөлөгчид ирж оролцож байгаа.

Тэгээд Хүний эрхийн дэд хороо сар тутам Хүний эрхийн форумтай сэдэвчлэн уулзалт хийж, тодорхой шийдэл дээр төвлөрсөн ажлуудыг хийж байгаа.

Тэгээд он гараад 2026 оны төлөвлөгөөнд ч гэсэн үргэлжлээд үр дүнг нь мөрөөр нь ажил авч арга хэмжээ авах ажлууд байгаа. Ингээд ажлын хэсэгтээ талархал илэрхийлье.

Эхний асуудал буюу Хүний эрхийг хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль болон Гамшгаас хамгаалах тухай хуулийн хүний эрхийн хэрэгжилтийн талаарх дүгнэлттэй танилцаж дууслаа. /алх цохив/

Ажлын хэсгийнхэн гарч болно. Баярлалаа.

**Хоёр.Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай
НҮБ-ын конвенцын хэрэгжилтийг сайжруулах,
зарим шаардлагатай арга хэмжээ авч хэрэгжүүлэх тухай
санал, зөвлөмжийг хэлэлцэнэ**

Хоёрдугаар асуудал. Хэлэлцэх асуудлын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцын хэрэгжилтийг сайжруулж, зарим шаардлагатай арга хэмжээ авч хэрэгжүүлэх тухай санал зөвлөмжийг хэлэлцье.

2025 оны 12 дугаар сарын 03-ны өдөр Улсын Их Хурлын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо болон Хүний эрхийн дэд хорооноос “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн тухай конвенцыг хэрэгжүүлэх оролцооны арга замуудыг бэхжүүлэх нь” сэдэвт бодлогын хэлэлцүүлгийг зохион байгуулсан.

Уг хэлэлцүүлгээс гарсан санал, зөвлөмжийг Улсын Их Хурлын гишүүн Хүрэлбаатарын Баасанжаргал танилцуулна.

Х.Баасанжаргал гишүүний микрофоныг нээе.

Х.Баасанжаргал: Энэ өдрийн мэндийг хүргэе.

Тэгээд 12 дугаар сарын 03-ны өдөр Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцыг хэрэгжүүлэхтэй холбоотой уг “Конвенцыг хэрэгжүүлэхэд оролцооны арга замыг бэхжүүлэх нь” гэсэн бодлогын хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо, Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо, Хүний эрхийн дэд хороо, Нэгдсэн Үндэстний Байгууллагын хөгжлийн хөтөлбөр, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг, эхийн холбоо, Тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбоо, “Гэрэлт цох байшин” төрийн бус байгууллага, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар гэсэн эдгээр байгууллагууд хамтарч Нэгдсэн Үндэстний Байгууллага дээр хэлэлцүүлгийг зохион байгуулсан.

Нийтдээ 120 гаруй олон улсын байгууллага, их дээд сургууль, төрийн байгууллага, төрийн бус байгууллагуудын 120 хүн оролцсон хэлэлцүүлэг болсон.

Энэ хэлэлцүүлгээс гарч байгаа зөвлөмж байгаа. Зөвлөмж бүгдээрээ Та бүхний гар дээр тараагдсан байгаа учраас би айхтар дэлгэрэнгүй нэг бүрчлэн унших илүүц байх.

Гагцхүү зүгээр энэ конвенцын хэрэгжилттэй холбоотой Улсын Их Хурал, Засгийн газар, яамд үндсэн чиг үүргийнхээ хүрээнд юу юу хийх ёстой юм, энэ төлөвлөгөө дээр юу юу, ямар ямар ажлууд үлдээд байгаа юм, тэр нь ямар учир шалтгаантай юм бэ гэдэг дээр илүү төвлөрч зөвлөмжийг гаргасан.

Зөвлөмжийг Хууль зүйн байнгын хороо, Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо, Хүний эрхийн дэд хороо гээд хамгийн түрүүнд манай Хүний эрхийн дэд хороон дээр танилцуулж байгаа. Та бүхэнд.

Цаашилбэл Хууль зүйн байнгын хороо болоод Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороон дээр танилцуулагдаад тэгээд энэ зөвлөмж өөрөө маш өргөн хүрээтэй буюу хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн асуудлыг бид зөвхөн хүний хөгжил, нийгмийн бодлогын асуудал, эсвэл Хүний эрхийн дэд хорооны асуудал гэдэг байдлаар харахгүй. Бусад бүх Байнгын хороо, бусад бүх яамдын үндсэн чиг үүрэгт хамаарах маш өргөн хүрээний асуудлууд дээр бид ахиц дэвшил гаргах үүргийг олон улсын байгууллагын өмнө хүлээсэн байдаг.

Тэгээд үүн дээр түлхэц болох. Ялангуяа зарим зүйлүүд дээр маш тодорхой зөвлөмжүүд гарсан. Яг юу хийх юм бэ гэдэг дээр тодорхой зөвлөмжүүд гарсан байгаа.

Тэгээд цаашид Монгол Улсын Их Хурлаас энэ конвенцын хэрэгжилттэй холбоотой тогтоол гаргах саналтай байгаа. Тэгээд гишүүд Та бүхнийг үүн дээр хамтарч дэлгэрэнгүй танилцаад тогтоол дээр дэмжиж оролцоосой гэж хүсэж байна.

Тэгээд гээд нийтлэг байдлаар гарсан 5, 6 асуудлыг нь товчхон бид дурдъя.

Яагаад Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцын хэрэгжилт манайд асуудлууд дагуулаад байна вэ гэвэл юуны өмнө төрийн байгууллага, бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч нар, конвенц, түүний агуулга, ач холбогдлын талаарх мэдлэг, ойлголт маш хангалтгүй, ойлголтын маш их зөрүүтэй байна.

Тэгээд энэ конвенцын нэг онцлог нь юу вэ гэвэл Нэгдсэн Үндэстний Байгууллагын хувьд хамгийн сүүлд боловсруулсан цогц хүний эрхийн конвенц гэдгээрээ онцлог.

Зарим судлаачид хэдийгээр Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц боловч энэ нь өөрөө хүний эрхийг дараагийн шатад ахиулсан чухал конвенц гэж үздэг. Зөвхөн хөгжлийн бэрхшээл гэдгээр хязгаарлахгүй. Энэ нь өөрөө хүний эрхийн хөгжлийн олон улсын гэрээ конвенцын хөгжилд гарч

байгаа маш том ахиц дэвшлийг илэрхийлсэн конвенц гэдгээрээ онцлог конвенц байдаг.

Тэгэхээр энэ дээр манай төрийн байгууллага шат шатдаа ойлголтын зөрүү маш их байна гэдгийг онцлон тэмдэглэж байгаа. Яамдын үйл ажиллагаа бодлогын түвшинд хоорондоо уялддаггүй. Зарим тохиолдолд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн хорооноос ирүүлсэн зөвлөмж Конвенцын үндсэн агуулга, зарчимтай зөрчилдөх үйл ажиллагааг хэрэгжүүлсээр ирж байгаа.

Тухайлбал Эрүүл мэндийн яамны зүгээс сэтгэцийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийг хүчээр үр хөндөх явдал ерөөсөө тасрахгүй байгаа. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас сэтгэцийн бэрхшээлтэй иргэдийн асрамжийн газрыг тусад нь байгуулах, Засгийн газраас 2024-2028 оны хооронд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөндөө 21 аймаг, 9 дүүрэгт “Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв” барина гээд үйл ажиллагааныхаа төлөвлөгөөнд тусгасан байгаа.

Эдгээр нь бүгдээрээ конвенцын холбогдох зохицуулалт, заалтуудыг зөрчиж байгаа гэдэг ийм зөвлөмжүүд ирдэг.

Төсвийг үр дүнтэй, оновчтой зарцуулдаггүйгээс үүдэн шаардлагатай тохируулга –

- “дохионы хэл”,
- “брайл орчуулагч”

туслах хэрэгсэлд зориулсан тодорхой төсөв жишээ нь хуваарилдаггүй. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй тэгш хамруулж чадахгүй байгаа.

Та бүхэн манай дэд хорооны энэ хуралдааныг шууд дамжуулж байгааг харж байгаа байх. Бас л “дохионы хэл”, “брайл” гээд холбогдох мэдээлэл хүртээмжтэй манай Их Хурал дээр хүртэл анхаарах ёстой олон зүйлүүд байгаа. Тодорхой хэмжээнд засагдаад явж байгаа.

Гэхдээ үүнийг эрчимжүүлэх хэрэгтэй байгаа. Аливаа бодлого, үйл ажиллагааг төлөвлөх, түүнийг хэрэгжүүлэхдээ шаардагдах статистик мэдээллийг бид огт гаргаж чадахгүй байгаа.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, асран хамгаалагчид бодлогын гадна орхигдох, төсвийн санхүүжилтийг үр ашиггүй зарцуулах, асрахуйн эдийн засгийн бодит үнэ цэнийг бид тодорхойлж чадахгүй ирсэн.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хамаарах асуудлаар бодлого, хууль тогтоомж боловсруулах бүх үе шатад эртнээс зөвлөлдөж, санал авах үйл явцад

дутагдалтай, мэдээлэлтэйгээр, мэдлэгтэйгээр санал өгөх оролцох боломжийг бид ерөөсөө хангаж чадахгүй байна.

Урьдчилж хүмүүстээ мэдээлэл ерөөсөө өгөхгүй байна гэдэг зүйл гардаг. Нийтлэг байдлаар. Хамгийн сүүлд орон нутаг болон салбарын түвшинд зөвлөх хороо хэлэлцүүлгийн тогтолцоо ерөөсөө байхгүй, хангалтгүй. Сонсгол гээд иргэдийн орол оролцооны олон механизмуудыг хуульчилсан боловч яг үр дүнтэй анхан шатан дээр, ялангуяа орон нутгийн түвшин дээр оролцооны механизмууд ажиллахгүй, хангалтгүй байна гээд маш дэлгэрэнгүй байдлаар зөвлөмжийг гаргасан.

Ингээд танилцуулга дууслаа.

С.Эрдэнэболд: Танилцуулгатай холбогдуулаад Хүний эрхийн Үндэсний Комиссын референт Б.Янжмаа, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөрийн “Оролцоо” төслийн техникийн зөвлөх Ц.Мандхайхатан нар хамт ирсэн байгаа.

Саяын танилцуулгатай холбогдуулж асуулт асууж, үг хэлэх гишүүд байхгүй байна.

Энэ дээр Улсын Их Хурлын гишүүн Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал, тулгамдаж байгаа асуудал дээр ер нь ямар гарц гаргалгаа, хуулийн хэрэгжилттэй холбогдуулж маш их санаачилгатай ажиллаж байгаа.

Үүнтэй зэрэгцээд Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун, Ж.Баясгалан нар 21 аймгийг тойрч, яг энэ хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьжиргааны асуудал, эдийн засгийн эрхийн асуудал, Үндсэн хуулиар олгогдсон эрхийг эдлэхтэй холбоотой асуудал дээр онцгой анхаарч яваа юм билээ.

Маргааш гэхэд Дархан, Сэлэнгийн бүс нутагт уулзалтуудыг нь хийх юм билээ.

Хүний эрхийн дэд хорооны 2025 онд хийгдсэн уулзалтуудын хүрээнд ч гэсэн яг энэ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хангах, хуульд гарсан хэрнээ тэр нь бодит амьдрал дээр хэрэгжихгүй байгаа зүйлүүд дээр тодорхойлох гээд олон олон зүйлүүд дийг авч үзсэн байгаа.

Цаашлаад дэд хорооны зүгээс болон Хууль зүйн байнгын хорооны зүгээс Их Хуралд танилцуулах, шийдэл гаргах дээр чиглэсэн зүйл дээр анхаарч ажиллах шаардлагатай гэж үзэж байгаа.

Тэгээд тэр утгаараа 2026 оны Хүний эрхийн дэд хорооны үйл ажиллагааны хөтөлбөр ч гэсэн энэ асуудал ороод явж байгаа.

Ингээд танилцуулга дууслаа. /алх цохив/

**Гурав.Хүний эрхийн дэд хорооны 2025 оны үйл ажиллагааны тайлан,
2026 оны төлөвлөгөөний төсөл**

Гуравдугаар асуудал. Хэлэлцэх асуудлын гуравдугаар асуудал. Хүний эрхийн дэд хорооны 2025 оны үйл ажиллагааны тайлан, 2026 оны төлөвлөгөөний төсөлтэй холбогдуулж мэдээллийг хийнэ.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны болон дэд хорооны гишүүддээ бид танилцуулга өгсөн байгаа.

2025 оны хүрээнд хэрэгжсэн нийт 19 ажлын төлөвлөгөөг өнгөрсөн оны 12 дугаар сард бид баталсан байгаа. Тэгээд үүнийг Улсын Их Хурлын гишүүддээ тарааж өгсөн байгаа.

Тэгээд манай дэгийн тухай хууль дээр юм уу энэ дэд хороод тайлан тавина, эсвэл дараа жилийн төлөвлөгөө хэлэлцэнэ гэсэн зохицуулалт байхгүй. Үүнийг цэвэр сайн дурын үндсэн дээр дэд хорооны ажлыг нээлттэй, ил тод, шилэн тунгалаг байлгах жишиг бүрдүүлэх зорилгоор хийж байгаа.

Тэгэхээр өнгөрч байгаа 2025 ондоо хийсэн ажлуудыг танилцуулж байгаа. Дээрээс нь ямар ямар ажил дээр ямар ямар ахиц дэвшил гарав гэдгийг олон нийтэд бид мэдээлэх зайлшгүй шаардлагатай гэж үзэж байгаа.

Яагаад гэхээр энэ хурал олон нийтэд өргөн нэвтрүүлгийн дэлгэцээр хүрч байгаа учраас танилцуулгыг эхэлье.

2024 оны ээлжит сонгуулийн үр дүнд бүрэлдэн байгуулагдсан шинэ парламентын бүрэн эрхийн хугацаанд тухайлбал 2024 оны 7 дугаар сараас 2025 оны 12 дугаар сар хүртэл Улсын Их Хурлын 3 ээлжит чуулган хуралдсан.

Уг хуралдаанд Хүний эрхийн дэд хороо нийт 3 удаа хуралдаж, нийт 473 оролцогчийг хамарсан 22 удаагийн уулзалт хэлэлцүүлгийг зохион байгуулсан.

Мөн иргэд, төрийн байгууллага, аж ахуй нэгж, иргэний нийгмийн байгууллагуудаас нийт 124 өргөдөл, гомдол, албан бичиг хүлээн авч, холбогдох хууль тогтоомжийн дагуу 121 хариу албан бичгийг хүргүүлж, шаардлагатай арга хэмжээг авч ажилласан.

2024 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн Хүний эрхийн дэд хорооны хуралдаанаар тус хорооноос 2024-2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсан.

Хүний эрхийн дэд хорооны үйл ажиллагааны түүхэн мэдээллийг судалж, үе үеийн дарга нартай уулзалт хийж, архивын баримтуудтай танилцаж, Хүний эрхийн Үндэсний комиссын гишүүд болон холбогдох байгууллагын удирдлагуудтай уулзалт зохион байгуулсны үндсэн дээр төлөвлөгөөний төслийг боловсруулж баталсан бөгөөд дараах 19 зорилгын хүрээнд арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан.

- ▶ Цагдан хорих 461 дүгээр хаалттай хорих ангийн үйл ажиллагаатай танилцаж, хүний эрх, эрх чөлөөг хангаж ажиллаж байгаа эсэх талаар санал, дүгнэлт гаргах.
- ▶ Хүний эрхийн Үндэсний комиссын гишүүн тус бүрийн үйл ажиллагаатай танилцаж, санал, дүгнэлт боловсруулах.
- ▶ Улсын Их Хурал болон түүний Тамгын газрын бодлого, үйл ажиллагаа, хүний эрхэд хэрхэн суурилсан талаарх судалгаа, шинжилгээ хийж, санал дүгнэлт боловсруулах.
- ▶ Хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр хяналт шалгалт хийх, холбогдох санал, дүгнэлт боловсруулах.
- ▶ Хилс хэрэгт хэлмэгдэж, улмаар шүүхээр цагаатгагдсан иргэдийн талаарх судалгаа хийж, уулзалт зохион байгуулан санал, дүгнэлт боловсруулах.
- ▶ Гадаадад амьдарч буй монгол иргэдийн хүний эрхийн нөхцөл байдлын талаарх санал, дүгнэлт боловсруулах –

-гээд ийм үндсэн чиг үүргийн хүрээнд байсан.

Тэгээд энэ 10-аад хуудас шахуу байгаа учраас би нэг бүрчлэн уншихаар илүү их цаг авах гээд байгаа.

Тэгээд ер нь гол гол ажлуудыг нь би тоймлоод хэлье гэж бодож байна.

Хүний эрхийн форумтой уулзалтыг нийтдээ 7 удаа хийсэн байгаа. Эндээс 50 гаран иргэний нийгмийн байгууллагуудаас бүрдсэн форумтой сар болгоны хоёр дахь долоо хоногийн лхагва гаргийн өглөөний 09.00 цагаас тогтмол уулзалтуудыг хийсэн.

Эдгээр уулзалт нь зөвхөн уулзаад зогсохгүй яг тодорхой сэдэвчилсэн хүрээнд хийсэн. Энэ уулзалтуудад манай Х.Баасанжаргал гишүүн маш идэвхтэй оролцсон. Манай Г.Уянгахишиг гишүүн маш идэвхтэй оролцсон. Б.Баярбаатар гишүүн, Х.Тэмүүжин гишүүн байж байна. Ц.Сандаг-Очир гишүүн.

Ер нь Хүний эрхийн дэд хорооны 11 гишүүн бүгдээрээ маш их идэвхтэй оролцсон. Тэгээд маш их талархал илэрхийлж байгаа.

Тэгээд энэ тайлан дээр хэдний өдөр ямар ямар хүмүүстэй яаж уулзсан бэ гэдэг нь. Уулзаад ямар ямар үр дүн рүү чиглэсэн алхмууд хийгдсэн бэ гэдэг нь гарсан байгаа.

Тэгээд Хүний эрхийн дэд хорооны 2024-2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хүснэгтэлсэн байдлаар Та бүхэнд өгсөн байгаа. Өөрөөр хэлбэл ямар зорилго дэвшүүлээд тэр яаж хэрэгжсэнтэй холбоотой холбоотой зүйл байгаа.

Иргэд, төрийн байгууллага, аж ахуй нэгж иргэний нийгмийн байгууллагаас ирсэн өргөдөл, гомдолтой холбогдуулаад 124 өргөдлийг яаж шийдсэн тухай байгаа.

Тэгээд мөн 2024 оны 11 сарын 06-наас өгсүүлээд **Эмнести Интернэшнл** (Amnesty International)-ын олон улсын нарийн бичгийн дарга, гадаадын яг энэ хүний эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг олон улсын байгууллагын төлөөлөгчтэй тухай бүрд нь уулзаж, Монгол Улсад хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөртэй холбоотой санал, дүгнэлтийг хуваалцах ийм асуудлууд байгаа.

Тэгээд 2025 оны энэ 11 дүгээр сард Нэгдсэн Үндэстний Байгууллага дээр Монгол Улсын хүний эрхийн төлөв байдлыг хэлэлцүүлэхтэй холбогдуулж урьдчилсан нэлээн олон уулзалт, арга хэмжээ, энэ тайлан дүгнэлтийг сайжруулахад чиглэсэн уулзалтуудыг нэлээн олон удаа зохион байгуулж хийсэн нь дүн, тоо, балл статистикаар энд орсон байгаа юм.

Тэгээд үндсэндээ 12 ажлын тайланг нэг бүрчлэн оруулсан байгаа. Үүнийг та бүхэндээ тайлан болгож оруулж байна.

Мөн Та бүхэнд гар дээр чинь хэвлээд тараагдсан байгаа хүснэгтэлсэн зүйл дээр яг тодорхой ямар ажлууд дээр ямар ямар шийдвэрүүдийг гаргаад ард талд нь яаж мөрөөр нь ажилласан бэ гэдгийг нь хүснэгт дээр оруулсан.

Жишээлбэл, нэг юуг татъя. Ахлах зөвлөх өө. Жишээлбэл, дэлгэц рүү хамгийн эхний ажлын хүснэгтийн 3 дугаар нүдэнд байгаа цахим холбоосыг оруулах юм бол ардаа энэ холбоосны дагуу тодорхой олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарсан фэйсбүүк байна уу. Тийм ээ. Сошиал суваг байна уу, түүн дээр гарсан зүйлүүдийг нь хавсаргасан байж байгаа. Тэгээд одоо манай дэд хороо чинь сошиал суваггүй байсан. Сошиал суваг нээгээд Хүний эрхийн дэд хороо гэсэн суваг ажиллуулж байгаа.

Тэгээд цөөхөн ч гэсэн чанартай хүмүүст хүртээмжтэйгээр мэдээллээ түгээх, ил тод байдлыг хангах чиглэл рүү ажилласан нь нийтдээ 10 гаруй хуудас тайлан болж орсон байгаа юм.

2025 онтой холбогдуулаад энэ дотроос асууж тодруулах зүйл байвал гишүүд асууж болно.

Тэгээд нэгэнт энэ чинь тайлан тавих, төлөвлөгөө батлуулах зохицуулалт байхгүй учраас дэд хорооны зүгээс санаачилгаараа үүнийг хийж байгаа учраас ямар нэгэн хүлээж авах санал асуулга, хураах юм байхгүй байна. 2025 оны тухайд ийм байна.

2026 оны тухайтад бидний ойлгож байгаагаар энэ оны 12 дугаар сарын 30, 31-нд намрын чуулган дуусаад 2026 оны 3 сарын 15-ны өдөр хаврын чуулган эхэлнэ.

Түүнээс өмнө нь 2026 ондоо хэрэгжүүлэх дэд хорооноос хийж хэрэгжүүлэх ажлын саналуудыг дэд хорооныхоо гишүүдээс наана нь аваад бүлэглээд, тэгээд хамтран хэрэгжүүлэх байгууллагуудтайгаа уулзаад төлөвлөгөөгөө уялдуулж 3 сарын чуулган нээгдэхээр дэд хорооныхоо хурлаар баталъя гэсэн саналтай байгаа.

Тэгээд дэд хорооны даргын асуудал эд нар яригдах болов уу гэж бодож байгаа учраас цааш нь авч явах манлайллын түвшинд асуудлыг ярилцаад явъя гэсэн итгэл үнэмшилтэй байна.

Ингээд дэд хорооны даргаар 2024 оны 12 сарын 22-ноос томилогдоод ажилласан өнөөдрийг хүртэлх тайлангаа товчхон танилцууллаа.

Тэгээд Та бүхний бүхэнд тараасан цаасан дээр дэлгэрэнгүй тайлангаас асууж тодруулах зүйл байвал Та бүхэн асууна уу. Байхгүй байна гэж үзлээ.

2025 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн Хүний эрхийн дэд хорооны хуралдаанаар 3 асуудлыг хэлэлцэж дууслаа.

Та бүхэнд баярлалаа. Хурал хаасныг мэдэгдье. /алх цохив/

Хуралдаан 51 минут үргэлжилж, 15 цаг 48 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД